

**"ДОРНОД ХУДАЛДАА" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 06 сарын 25-ны өдөр

Дугаар 2026/02

Чойбалсан хот

"Дорнод худалдаа" хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралд Д.Тунгалагтуул, Д.Шинэбаяр, Ш.Билгүүн, Ш.Нямдулам, Н.Намсрайжав, Д.Эрдэнэболд нарын удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн 66.7%-ийн ирцтэйгээр компанийн 204 тоот хурлын өрөөнд 2026 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн Лхагва гарагийн 10:10 минутад эхлэв.

Хурлын дарга Д.Тунгалагтуул, тооллогын комиссын дарга Ш.Билгүүн, гишүүд Д.Эрдэнэболд, Ш.Нямдулам нар ажиллав.

Хуралд оролцож буй ширхэг хувьцаа нь 49970 ширхэг хувьцааны 67,57 хувийг бүрдүүлж байгаа тул хурал хуралдах ирц бүрдсэн болохыг мэдээллэв.

Д.Тунгалагтуул (хурлын дарга) – Энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд зөвлөлийн ээлжит бус хурлын ирц бүрдсэний дагуу хурлыг эхлэе. Хурлыг даргалж байгаагийн хувьд эхлээд хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг батлах нь зүйтэй. Хурлын дэгийг танилцуулая.

1	Хурлын ирцийг бүртгэх (тооллогын комисс)	10:00-10:15
2	Хурлын ирцийг мэдээллэх (тооллогын комисс)	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх,	10 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	30 минут
5	Асуулт, хариулт, санал шүүмжлэл тавих	30 минут
6	Санал хураалт	20 минут
7	Хурлын завсарлага	15 минут
8	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10	Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналтай батлав.

Нягтлан бодогч И.Баярцэцэг 2025 оны үйл ажиллагааны тайлан болон 2025 оны санхүүгийн тайлангийн талаар, хурлын дарга Д.Тунгалагтуул төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг хэлэлцэх тухай.
3. 2026–2027 оны бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын чиглэлийг батлах тухай.
4. 2026 онд ногдол ашиг хуваарилах эсэх тухай.

СОНСОВ:

Д.Тунгалагтуул (хурлын дарга) – Бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал эхэлснийг мэдэгдэе.

1. Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн сонгох талаар санал хүсэлтээ хэлэлцээд явая.

2 дугаарт: Компанийн захирал Д.Шинэбаяр 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг танилцуулна.

3 дугаарт: Өнөөдрийн хурлаар бид 2026-2026 оны бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын чиглэлийг батлах тухай

4 дүгээрт: 2026 онд ногдол ашиг хуваарилах эсэх гэсэн 4-н гол үндсэн асуудлаа дэвшүүлж хэлэлцээд явая.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Ш.Билгүүн (тооллогын комиссын дарга) – Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хурлын даргын танилцуулсан хэлэлцэх асуудлын 1-дүгээр асуудал буюу төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэл хийх нь маш нэн тэргүүний асуудал байна. Учир нь манай байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд зарим гишүүд оролцооны хувьд хангалтгүй байгаа нь гол асуудал юм. Иймд та бүхэн санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлж хасах болон нэмэх гишүүдийн нэрийг нээлттэй дэвшүүлнэ үү.

Д.Шинэбаяр – За бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Хэлэлцэх асуудлын гол асуудал бол үнэхээр зарим төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн оролцоо хангалтгүй байгаа нь бидний цааш цаашдын ажлын төлөвлөлт ахиц дэвшилтэд шууд ба шууд бусаар нөлөөлж байна гэж би харж байна. Иймд нэр бүхий төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ шинэ бүрэлдэхүүнээр солих нь зүйтэй гэж үзэж байна. Жишээ нь: Ц.Содбаяр, Ц.Содхүү зэрэг гишүүдийг төлөөлөн удирдах зөвлөлөөс хасаж, Намхайн Энхболд, П.Пүрэвэе нарыг санал оруулж байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Д.Эрдэнэболд – Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах саналыг 100% дэмжиж байна. Оролцоо хангалтгүй гишүүдийг одоо хасаж шинэ бүрэлдэхүүн томилох нь зөв. П.Пүрэвэе бол бас бизнес хийж яваа өсөлттэй яваа залуу би дэмжиж байна.

Ш.Нямдулам – Төлөөлөн удирдах зөвлөл гэдэг бол байгууллагын хувьд маш том хариуцлага гэж би харж байна. Тиймээс бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж оролцоо хангалтгүй гишүүдийг хасаж шинэ бүрэлдэхүүн томилох нь зөв дэмжиж байна.

Д.Тунгалагтуул – Энэ байгууллагад ямарч хамааралгүй юм шиг хариуцлагагүй идэвх оролцоогүй гишүүдэд бүрэлдэхүүний өөрчлөлт оруулж Ц.Содхүү, Ц.Содбаяр нарыг төлөөлөн удирдах зөвлөлөөс хасахыг дэмжиж байна. Мөн П.Пүрэвэе, Н.Энхболд нарын туршлага, нийгмийн оролцоо болон компанийн цаашдын хөгжлийн бодлоготой уялдуулан саналыг дэмжиж байна.

Н.Намсрайжав - Миний хувьд олон жил энэ байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр хуралд оролцож байна. Та бүхний саналыг санал нэгтэй дэмжиж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар дараах иргэдийг "Дорнод худалдаа" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов.

- Д.Тунгалагтуул
- Д.Шинэбаяр
- Ш.Билгүүн
- Ш.Нямдулам
- Д.Эрдэнэболд
- Н.Энхболд
- Н.Намсрайжав
- Ц.Шинээориг
- П.Пүрэвэ

Санал хураалтын дүн:

- Зөвшөөрсөн: 100%
- Татгалзсан: 0
- Түдгэлзсэн: 0

Асуудал 2. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

СОНСОВ:

Гүйцэтгэх захирал Д.Шинэбаяр компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг танилцуулав.

ХЭЛЭЛЦЭВ:

Д.Тунгалагтуул- Өнгөрсөн онд бид одоогийн "Маргад", оффис худалдаа үйлчилгээний 5 давхар барилгын ажлыг эхлүүлж багагүй цаг хугацаа хөрөнгө мөнгө зарсан ч нийгмийн хариуцлагын хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлж чадсан. Одоо ч бид дараа дараагийн барилгын ажлуудаа төлөвлөөд эхнээсээ баригдаад явж байна. Одоогоос 3 жилийн өмнө бид барилгажих боломжтой хуучны түр барилгуудыхаа газрыг ашиглаад үе шатны төлөвлөлтэйгээр шинэ худалдааны төвүүдийг барихаар төлөвлөж байсан бол одоогийн байдлаар бүтээн байгуулалтын ажлууд хийгдсээр байна. Ирэх онд Жаргалангийн суурин дээр баригдаж байгаа барилгаа ашиглалтад өгчихвөл дараагийн оноос санхүүгийн байдал жигдрэнэ гэж харж байгаа. 2024-2027 он хүртэл засвар үйлчилгээ, тохижилт барилгын ажлууд шат дараатай төлөвлөгөөтэй тасралтгүй хийгдсээр яваа.

Д.Эрдэнэболд – Манай байгууллагын хувьд маш сайн бүтээн байгуулалт, урсгал засварын ажлууд хийгдэж байгааг бид бүгд харж байна. Санхүүгийн тайланд дүгнэлтийг зөвшөөрч байна.

Ш.Нямдулам- Манай зах жил ирэх тусам өнгө төрхөө нэмэхийн төлөө хичээж төлөлтийн дагуу ажлууд хийгдээд явж байгаа нь сайшаалтай байгаа. Аймаг орон нутагтаа ажлын байрыг жил тутам нэмэгдүүлэн ажиллаж байгаа. Санхүүгийн тайланд санал зөрөх асуудал байхгүй ээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг 100% зөвшөөрсөн.

Санал хураалтын дүн:

- Зөвшөөрсөн: 100%
 - Татгалзсан: 0
 - Түдгэлзсэн: 0
-

Асуудал 3. 2026–2027 оны бизнес төлөвлөгөө

СОНСОВ:

Д.Шинэбаяр- Ерөнхийдөө бид сүүлийн жилүүдэд дан бүтээн байгуулалтын жилүүд өрнөж байна. Үүнтэй холбогдуулан та бүхэнд 2026–2027 оны бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын чиглэл, бүтээн байгуулалтын ажлын талаар танилцуулга хийв.

ХЭЛЭЛЦЭВ:

Д.Шинэбаяр- Энэ жилээс Билгүүн компанийн дэд захирлаар ажиллаж байгаа шинэ залуу үе залгамж халаагаа авч цаашдын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын чиглэл, бүтээн байгуулалтын ажлууд улам их сайжирч явна гэдэгт итгэлтэй байна. Та бүхэнд 2026-2027 оны бизнес төлөвлөгөөнд оруулах санал хүсэлт байвал хэлээрэй.

Ш.Нямдулам- Дэд захирал Ш.Билгүүндээ амжилт хүсье. Нэмэлт санал хүсэлт байхгүй. Бизнес төлөвлөгөө, төлөвлөлтөд оруулах санал байхгүй ээ.

Н.Намсрайжав- Манай байгууллагын хувьд сүүлийн жилүүдэд улам л сайжирч байгаа ерөнхийдөө засан сайжруулах шаардлага бүхий захууд бас байгаа тэгээд урсгал засварууд бас төлөвлөлтөд орсон харагдаж байна. Санал хүсэлт байхгүй ээ.

Ш.Билгүүн – Илүү өргөн цар хүрээнд цаашдын том зургыг харж төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөрөнгө оруулалтын өгөөж болон санхүүжилтийн асуудлыг харгалзан үзэж боловсруулсан төлөвлөлт байна гэж харж байна. Надад нэмж хэлэх санал хүсэлт байхгүй.

Д.Тунгалагтуул- Жил дараалан барилгын ажлууд хийгдэж байгаа тул санхүүгийн байдалдаа тулгуурласан ч ерөнхийдөө хөрсөндөө буусан төлөвлөлт байна гэж харж байна. Санал хүсэлт байхгүй ээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Компанийн 2026–2027 оны бизнес төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллахыг дэд захирал Ш.Билгүүнд даалгасугай.

Санал хураалтын дүн:

- Зөвшөөрсөн: 100%
 - Татгалзсан: 0
 - Түдгэлзсэн: 0
-

Асуудал 4. Ногдол ашиг хуваарилах тухай

СОНСОВ:

Д.Тунгалагтуул (хурлын дарга)- Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төслүүд болон цаашдын хөгжлийн бодлогыг харгалзан 2026 онд ногдол ашиг хуваарилахгүй байх саналыг танилцуулав.

ХЭЛЭЛЦЭВ:

Ш.Билгүүн- Хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилах боломж болон хөрөнгө оруулалтын хэрэгцээний талаарх шалтгаан хангалттай байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байх саналыг дэмжиж байна.

Д.Шинэбаяр- Сүүлийн жилүүдэд барилга ашиглалтад өгч байгаатай холбогдуулан ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаа нь үнэн тиймээс ногдол ашиг хуваарилахгүй саналыг 100 хувь дэмжиж байна.

Д.Эрдэнэболд- Өө ямарч асуудал байхгүй энэ жилийн хувьд ногдол ашиг хуваарилах гэхээс илүү маш том бүтээн байгуулалтууд хийгдэж байгаа. Тиймээс ногдол ашиг хуваарилахгүй байх саналыг 100 хувь зөвшөөрч байна.

Н.Намсрайжав- Ногдол ашиг хуваарилахгүй байх саналыг 100 хувь дэмжиж байна.

Ш.Нямдулам- Та бүхэнтэй санал нэг байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Компанийн тухай хуулийн 46.5 дахь заалтыг үндэслэн 2026 онд ногдол ашиг хуваарилахгүй байх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн саналыг гишүүд 100% зөвшөөрөв.

Санал хураалтын дүн:

- Зөвшөөрсөн: 100%
- Татгалзсан: 0
- Түдгэлзсэн: 0

4. ХАВСРАЛТ

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол
2. Санал хураалтын дүнгийн нэгтгэл
3. Хурлын ирцийн бүртгэл

ХУРЛЫН ДАРГА:

Д.Тунгалагтуул

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Б.Батцэцэг